



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/11

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.3, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах” тухай 03 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Түр журам батлах” тухай А/08 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд сумын малчин өрхүүдэд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.


2. Түр журам, ажлын төлөвлөгөөний дагуу тэжээл олгох ажлыг шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2021 оны
01 дүгээр сарын 18-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг даргын Орлогч

Гишүүд: С.Самдан – Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Мөнхбат – Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Б.Пагамдулам - 1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян – 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв – 3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом – 5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан – 6 дугаар багийн Засаг дарга

Т.Сундуйбаяр - Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч

Г.Оюунмандах - Нягтлан бодогч

М.Чимэдрэгзэн - Нярав

-оОо-